



30

БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БАЯНХОНГОР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/17

Номгон

Мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн,  
нэмэлт тэжээл худалдаалах, борлуулах  
үйл ажиллагаанд хяналт тавих тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.1, 31 дүгээр зүйлийн 31.3.2, 31.6.2, Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.15, 13 дугаар зүйлийн 13.9, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын нутаг дэвсгэрт мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, нэмэлт тэжээл явуулын худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжид хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Батцэцэг

(Мал эмнэлгийн тасгийн хяналтын Улсын  
байцаагч)

Гишүүд:

Б.Ганшүүдэр

(Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

Ж.Дэлгэрмаа

(Байгаль орчны хяналтын Улсын байцаагч)

Б.Баасанжаргал

(Хүнс хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Ө.Цэвээнбат

(Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)

Т.Дагдмаа

(Орлого хариуцсан ажилтан)

Нарийн бичгийн дарга:

Б.Ууганзаяа

(Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан  
мэргэжилтэн)

Захирамж 2023 он

671010831

2.Мах, сүү, нэмэлт тэжээлийг худалдаж буй иргэн, аж ахуйн нэгжид хяналт шалгалтыг зохион байгуулж, холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулж, зөвшөөрөгдсөн цэгийг тодорхойлж, түр худалдаа эрхлэгчийг байршуулах, татвар хураамжийг авч, хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, үүрэг даалгавар биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцож, ажлын тайланг нэгтгэн танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (С.Батцэрэн)-д даалгасугай.

ДАРГА



С.БЭНХБАЯР